



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар 5/28

Хэрлэн сум


Урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2, 1.2.2, 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Жаргалын Гантулгад хоёрдугаар улирлын мөнгөн урамшуулал олгосугай.

2.Улирлын мөнгөн урамшууллыг албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ